

## “ЭМО-АУДИТ” ХХК

Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн  
тайлангийн баталгаажуулалт, зөвлөгөө өгөх  
үйлчилгээний итгэмжлэгдсэн байгууллага



## “EMO-AUDIT” LLC

Accounting, Auditing,  
Consulting and Appraisal firm

2022 оны 02 сарын 15 өдөр

№ 089

Улаанбаатар хот

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

## “БӨӨНИЙ ХУДАЛДАА” ХК-ИЙН УДИРДЛАГАД

### Дүгнэлт

Бид “БӨӨНИЙ ХУДАЛДАА” ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгон бэлтгэсэн санхүүгийн байдлын, үйл ажиллагааны үр дүнгийн, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний холбогдох тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлэгдсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа аудиторын ёс зүйг баримтлан Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартуудын дагуу санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой нотолгоо олж авахын тулд ёс зүйн шаардлагуудад нийцүүлж, аудитаа төлөвлөж гүйцэтгэлээ.

Нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу бид тухайн аудит гүйцэтгүүлэгч байгууллагаас хараат бус бөгөөд хууль болон НББЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв бөгөөд шударгаар толилуулагдсан гэдгийг үндэслэлтэй баталгаажуулж, аудиторын дүгнэлтэнд хүрлээ.

## Аудитын гол асуудлууд

Санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхүйц асуудал байхгүй.

## Удирдлага ба Засаглах удирдлагын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, мөн нөхцөл байдалд уялдсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх хариуцлагууд багтана.

## Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Аудиторын хүлээх үүрэг хариуцлага нь хийж гүйцэтгэсэн аудитад үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар дүгнэлт гаргах байдаг. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэдэг бөгөөд аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн.

Аудитын явцад санхүүгийн тайлагналыг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцооллуудын үндэслэлтэй байдал, хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний хийсэн аудит багтаасан.

Аудитын Олон Улсын Стандартын дагуу бидний хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байж болзошгүй залилан ба алдааг бүрэн илэрхийлнэ гэсэн баталгаа биш боловч аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж бид үзэж байна.



/Д.Оюунчимэг /  
Ерөнхий захирал

Хаяг: УБ, Чингэлтэй Дүүрэг, 2-р хороо,

Номин Шарга төв, 403 тоот

Утас: 99065995, 99139559

И-мэйл: [ac.oyunaa@gmail.com](mailto:ac.oyunaa@gmail.com)

